



ЭВТЭЙ БАЙХДАА ХҮЧТЭЙ

STRENGTH IN UNITY

Нанзаддоржийн Жалбажав¹

Shihuhutug University, E-mail: jalbajav@shihuhutug.edu.mn, <https://orcid.org/0009-0002-6995-7559>

ӨГҮҮЛЛИЙН ТУХАЙ

ХУРААНГУЙ

Түлхүүр үгс:

Эе эв, үндэсний эв нэгдэл, үндэстэн угсаатан, нийгмийн бүлэг давхарга, олон ургалч үзэл

Нийтлэлийн түүх:

Хүлээн авсан: 2026, 03 сар
Шинэчилсэн: 2026, 03 сар
Хүлээн зөвшөөрсөн: 2026, 04 сар

Keywords:

Mongolia, Mongolians, National Harmony, National Unity, Social Cohesion, Chinggis Khan, Companionship and Brotherhood, Mongolian Political Thought, National Identity, Social Solidarity, Political Pluralism, National Security.


Article history:

Received March, 2026
Revised March, 2026
Accepted April, 2026

Өгүүлэлд Монголын төр улсын бат оршихуйн нэгэн үндэс болсон үндэсний эе эвийн хүчний утга учир, түүхэн уламжлал, ач холбогдлын тухай товч авч үзсэн болно. Зохиогч чөлөөт зах зээлийн харилцаа, ардчилал, олон ургалч үзэл дэлгэрсэн энэ цаг дор нийгмийн ухамсар сэтгэлгээнд эе эвээ хичээх сэтгэлгээг төлөвшүүлэх, үндэсний эв нэгдлээ бэхжүүлэх арга замын тухай санаа бодлоо илэрхийлээд монголын ард түмний эе эвийн сэтгэлгээ, үндэсний эв нэгдлийн нэгэн эх сурвалж болох суут богд Чингисийн андын нөхөрлөлийн утга учир ач холбогдлыг тодорхойлохыг зорьсонд өгүүллийн ач холбогдол оршино гэж үзэж байна.

This article examines the meaning, historical foundations, and contemporary significance of national harmony as one of the fundamental pillars of the stability and endurance of the Mongolian state. Drawing upon Mongolian historical sources, philosophical traditions, and the teachings of Chinggis Khan, the study highlights the enduring value of social cohesion, mutual respect, and solidarity in maintaining national unity. The author argues that in the context of democracy, a market economy, political pluralism, social stratification, and increasing diversity of interests, strengthening a culture of harmony and mutual understanding has become an important prerequisite for sustainable national development and security. Particular attention is devoted to the institution of friendship and companionship among Chinggis Khan and his loyal companions, which is interpreted as a historical source of Mongolian traditions of unity and collective responsibility. The article further discusses contemporary challenges to national cohesion, including political polarization, regionalism, ethnic misconceptions, and social inequality, and proposes policy directions for reinforcing national solidarity and social trust in Mongolia.

¹Шихихутуг их сургуулийн Зөвлөх профессор, доктор (Ph.D), профессор



Энэ өгүүлэл CC BY-NC лицензийн дагуу нээлттэй хандалтын эрхтэй.



1. Судалгааны үр дүн

“Монголчууд эвтэй байхдаа хүчтэй байдаг” гэсэн эе эвээ хичээх сэтгэлгээ нь “Монголын нууц товчоо”, “Эрдэнийн эрхи”, “Алтан товч”, “Судрын чуулган” “Эрдэнийн сан Субашиди” зэрэг судар бичиг, түүх шастир, үлгэр домог Чингис хаан, их хаадын сургаал, бичиг захидлуудад дархлагдаж үеэс үед уламжлагдан иржээ.

Алангуа эхийн домгоос аваад “Арга хүчээ их болгоё гэвэл ард цэрэг юугаан асар, уужим сул тарааа гэвэл эе эв юугаан ямагт хичээ”, Бие хэврэг, билиг мөнх. Улсын эзэн сайд хэн ч бай олондоо хүндлэгдсэн эрдэмтэн мэргэд ухаантныг гүнээ хүндэтгэх хэрэгтэй “Бие бөх болбоос ганцыг яльюу, эе эв бөх болбоос олныг яльюу” гэсэн Чингис богдын сургаал хэзээ ч үл хуучрах оюуны их өв бөгөөд хүмүүний хооронд, улс оронд эе эвийг эрхэмлэх нь өрх гэр, улс орон энх амгалан, хүчирхэг, аюулгүй оршихын нэгэн баталгаа болохыг нотолж байдаг.

“Эе эвээ нэгтгэн олноор хамжвал
 Эгэл дорд улс ч байв их үйлсийг бүтээюү
 Эрт цагт нэгэн арслангийн зулзагыг олон шоргоолж
 Энд тэндээс нь зэрэгцэн хазсаар алсан үлгэр мэт (Субашид 56 дахь талд) гэсэн сургаал нь эе эвийн тухай монгол философи сэтгэлгээний илэрхийлэл юм.

Ата Малик Жувейны “Дэлхийг байлдан дагуулагчдын түүх” шастиртаа Чингис богд “Хөвгүүд, дүү нартаа ямагт эв найртай байж, бие биедээ тус дэм өгч, эе эвээ бэхжүүлэхийг чармайх хэрэгтэй гэж үргэлж захин сургах, явал эвтэй байх ... тухай үлгэр жишээг таниулдаг байсныг тэмдэглэж үлдээжээ.

Хоёр хүн эвтэй болбоос
 Төмөр хүрээ мэт бэх
 Хорин хүн эвгүй болбоос
 Эвдэрхий хүрээ мэт хэврэг
 Өнөр хүн эвгүй болбоос
 Өнчин хүний элэг болох
 Олон хүн эвгүй болбоос
 Оорцог (нөхөргүй, зожиг хүн, ред.) хүний идэш болох” хэмээсэн нь Чингис хааны эе эвийн үзэл баримтлал нь юм.

Плано Карпини “Тэд/монголчууд/ хоорондоо маргаж, хэрэлдэнэ гэж бараг үгүй, зодолдох, өөр зуураа дайтах, муудалцах бие биеэ алж шархдуулах явдал огт байхгүй” гэжээ (Монголчуудын түүх. 22 дахь талд). Гэхдээ Академич С.Нарангэрэл “Чингис хааны ёс суртахуун – эрх зүйн шастир”-таа эрх мэдэл булаалдах албан тушаал хөөцөлдөх, хахуульд идэгдэх, хов жив, гүжир гүтгэлэг, хувийн ашиг хонжоог урьтал болгох явдал эв эеийн суурийг ганхуулж, түүхийг эвдэн нураадаг болохыг монголчуудын үе үеийн түүх баталсан юм” гэдгийг онцлон тэмдэглэжээ. Рашид-ад-дины “Судрын чуулган”-д Жочи (Зүчи), Цагадай хоёрын зөрчил Хорезмын дайнд ямар уршиг тарьсныг сургамжлан бичсэн нь бий. (121 дэх талд)

Монголын түүхэнд Хубилай, Аригбухын тэмцэл, их хаад (Өгөдэй, Цагадайн удмынхан хийгээд Гүег нарын зөрчил, хожим феодалын бутрал гээд монголын хүч чадлыг сулруулж улмаар бусдын (Манжийн) эрхшээлд ороход хүргэж байсан гашуун туршлага, сургамж бишгүйдээ бий.

Ер нь эе эвээ хичээх сэтгэлгээ, ёс журам бол зөвхөн монголчууд төдийгүй үндэстэн угсаатан, ястан бүрийн өөдрөг, энх амгалан оршихуйн нэгэн үндэс суурь нь болой. Энэтхэгийн Дж.Неру, Их Британийн У.Черчилл, АНУ-ын Фр.Рузвельт, Хятадын Дэн Сяо Пин нарын олон үндэстний улс гүрний их удирдагч нар болон ертөнцийн мэргэд ч шударга ёс бол нийгмийг ариутгагч, үндэсний эв нэгдлийг бэхлэгч, ялалт амжилтын нэгэн эх сурвалж болохыг сургасан нь цөөнгүй.

Тухайлбал Фр.Рузвельт АНУ XX зууны 20-30-аад оны их хямралыг улам хүчирхэгжин сэргэн мандаж туулсны гол учир нь америкчууд хүн төрөлхтний ардчилал, эрх чөлөөний манлай орны иргэд гэдгээ ухаарч эв нэгдэлтэй байсны үр ач гэжээ .

Монгол Улс хэдийгээр нэг үндэстэн (халх, хүн амын 80 хувь нь) давамгайлсан, төрийн унитар буюу нэгдмэл тогтолцоотой боловч халх, хасаг, буриад, дөрвөд, баяд, чантуу, торгууд зэрэг 10 гаруй үндэстэн ястны өлгий орон.

Монголын төр 2200 гаруй жилийнхээ түүхэнд үндэстэн, ястнаа их бага гэж ялгаварлалгүйгээр хэл соёл, зан заншлыг хүндэтгэн эрх тэгш, эв нэгдэлтэй аж төрөх бодлого баримталж иржээ. Үүний үрээр Монголын соёл, иргэншил олон ястан, угсаатны соёлын бат цулыг бүрдүүлэн хөгжиж буй билээ.

Эдүгээ Монголд ардчилал түгэн, хувийн өмчид суурилсан зэх зээлийн харилцаа төлөвшин, үндэсний ухамсар, соёл хөгжих таатай нөхцөл бүрдэн байна. Үүний сацуу зах зээлийн чөлөөт өрсөлдөөн, хувийн өмчийн өсөлт хөгжил нь нийгмийн социал ялгарал, баян чинээлэг байдал, ядуурлын зөрүүг ихэсгэн нийгмийн өөр өөр ашиг сонирхол бүхий бүлэг давхаргууд төлөвших үндэс болж байна. Эрдэмтэн судлаачдын судалгаанаас үзэхэд эдүгээ Монгол Улсад баячууд, хүн амын чинээлэг хэсэг буюу дундчууд, ядуучууд, нэн ядуу хэсэг буюу үгээгүйчүүд (өмч хөрөнгөгүй, тогтмол орлогогүй, олдсоноор амь зуудаг, зарим нь орон гэргүй) гэсэн социал давхаргажилтын ерөнхий дүр зураг ажиглагдаж байна. Социал ялгарал, олон ургалч үзэл бодол, ашиг сонирхлын зөрүү

зэргийг зарим эрдэмтэн судлаачид “төвөөс зугтах” хүчин, задралын далд совин гэх зэргээр нэрлэж байна.

Чөлөөт өрсөлдөөн, бизнесийн эрх чөлөө нь улс орон хэмээх нэгэн бүлийг бүрдүүлж буй үндэстэн, ястны эдийн засгийн харьцангуй бие даасан байдлыг бэхжүүлэхийн сацуугаар үндсэрхэх, нутгархах, явцуурах үзлийг нь өдөөн сэргээх нигууртай. Хэрвээ төрийн эдийн засаг, нийгмийн бодлогод нийгмийн бүлэг, давхарга, үндэстэн, ястны хувьд нийгмийн материал баялгийн хуваарилалт, хөрөнгө оруулалт, татварын бодлого зэрэгт шударга ёсны зарчим алдагдах, хүн амын дунд үндэс угсаа, шашин шүтлэг, хэл соёлын өчүүхэн төдий ч ялгаварлах хандлага гарах, газар авбал урьдчилан тооцоолох аргагүй уршиг тарих, салан тусгаарлах, санаа бодол, үйл ажиллагаа үржин төлжих хөрс нь болдгийг Испани (Барселона), Их Британи (Шотланд, Умард Ирланд), Хятад (Шинжан, Уйгар), Украин (Донбасс), Ойрх Дорнодод өрнөн буй үндэсний асуудал, зөрчил тэмцэл харуулж байна.

Монгол Улсад үндсэрхэх, нутгархах үзэл бодол цухалзсаар буйг нуух юмгүй мэт. Унасан газар, угаасан ус, яс үндэс, угсаа гурвалаараа бахархах нь эрүүл ухаантай хүн бүрд заяагдсан мэдрэмж ухаарал. Гэхдээ энэ нь голдирлоосоо хальж бүлгэрхэн явцуурах, бүтээн байгуулалтын бодлого тодорхойлох, боловсон хүчнийг шилж сонгох зэрэг төрийн бодлогын зүйлд нөлөөлөх, түүхийг мушгин гуйвуулах, зиндаанд хүрвэл уршгийг нь тааварлах аргагүй. Бөхөө барилдуулахдаа хүртэл ихэд нутгархан талцах болсон нь өөгшүүлэх зүйл огт биш. Ерөөс онцгойрох, ялгарах зүйлээрээ түрүү барих нь орон гэрээ бусниулах нигууртайг эцэг дээдэс маань сургаж, сургамжилсан байдаг нь цөөнгүй.

Нэгэн зүйлийг онцлон тэмдэглэхэд гадаадын болон дотоодын зарим судлаачид (uradvn E.Bulag, Бат-Отгон зэрэг) Монгол Улсад үндэсний эв нэгдлийн зорилгод хор хөнөөл учруулж мэдэх угсаатны улс төрийн хямрал (ethnico-political crisis) бий болсон (uradvn E.Bulag: “Монгол дахь ястны үзэл ба үндэсний эв нэгдэл, тэдгээрт холбогдох эрх зүйн асуудал”.УБ.,2020 он.52, 58-59 дэх талуудад), угсаатан, үндэстний ангиллын төөрөгдөл их байгаа зэрэг нь улс үндэсний эв нэгдэл, аюулгүй байдалд уршиг тарьж мэдэх зүйл гэснийг огт анзаарахгүй байхын аргагүй.

Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал зэрэгт үндэсний, үндэстний, угсаатан, ястан, үндэстний олонх, цөөнх зэрэг ойлголтыг өөр өөрөөр тодорхойлсон, Үндэсний статистикийн тайлан, мэдээ, хүн амын тооллогын үр дүн, хүн амын бүртгэл судалгаа, мөн Монгол Улсын Элчин сайдын яамдын зүгээс гадаад орнуудад түгээж буй сурталчилгааны материалуудад дээрх ангилал, ойлголтын ихээхэн зөрүүтэй байгаа, мөн тэдгээрийн Англи, Орос, Герман, Хятад, Испани зэрэг гадаад хэлэн дээр орчуулга бүр ч ойлгомжтой бус зэрэг нь улс төрийн бүр ч ноцтой алдаа, уршиг, үр дагаварт хүргэх нигууртайд дүгнэлт хийн холбогдох судалгаа дүгнэлт хийх, эмхлэх, цэгцлэх хэрэгтэй болсныг онцлон тэмдэглэж байна.

Күнзийн номлолд “Нэрийг зөв хэрэглэхгүй бол хэл яриа зөв биш болно. Хэл яриа зөв биш бол үйл хэрэг амжилт эс олно. Үйл хэрэг амжилт эс олбол ёслол, хөгжим бадрангуй биш болно. Ёслол, хөгжим бадрангуй биш бол ял шийтгэл шударгаар

оногдохгүй. Ял шийтгэл шударгаар оногдохгүй бол эгэл ард түмэн хаана толгой, хөлөө тавихаа (хэрхэн амьдрахаа) эс мэднэ. Иймээс төрийн хүн аливаа зүйлийг нэрлэсэн нөхцөлд уг нэршил хэл ярианд тусгагдаж үйлдэл болдог. Төрийн хүн үг хэлэхдээ дур зоргоороо авирласан байж болохгүй ээ”. (Күнзийн сургаал, Англи хэл дээр, New York. Columbia University Press, 88-89 дэх талуудад)

Нийгмийн оюун санаанд ч зарчмын гэмээр өөрчлөлтүүд гарлаа. Иргэдийн ертөнцийг үзэхүй, амьдрах хэв маяг, үнэт зүйлсийн чиг баримжаа үндсээрээ өөрчлөгдөн улс төрийн олон ургалч үзэл дэлгэрч олон төрөл шашин шүтлэг чөлөөтэй нэвтэрч, нутагшин байна. Ганцхан жишээ дурдахад Монгол Улсад бүртгэлтэй, бүртгэлгүй христийн, лалын болон бусад шашин, сүм хийд, мөргөл шүтлэгийн байгууллага, газрын тоо хэдэн зууд хүрч тэдгээрийн шүтэн бишрэгчдийн тоо 100 мянгаас хол давжээ.

Ертөнцийг үзэхүйн өөр үзэл бодол, итгэл үнэмшлийг үл тэвчигч (ийм шинж байдал загалмайтны, лалын болон бусад олонх шашинд байдаг) олон шашин дэлгэрсэн улс орныг торхтой дарин дээр сандайлагч нэгэнтэй зүйрлэсэн нь бий. Шинэ нөхцөл байдалд төр, шашны харилцааг үндэсний аюулгүй байдал, үндэснийхээ соёл, иргэншлийг хангах, хамгаалах болон иргэнийхээ улс төрийн, шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хангах бодлогын зангилаан дээр хууль зүйн ухаалаг, оновчтой зохицуулалт хийх, түүний дотор монголчуудын соёлын их уламжлал, сан хөмрөгийг өөртөө агуулсан эцэг өвгөд, ахмадуудаас аваад монголчуудын олонхын оюун санаа, яс маханд нь шингээстэй уламжлалт шашныхаа статусыг оновчтой тодорхойлох нь төрийн бодлогын тулгар асуудал гэж үзэж байна.

Энэ цаг үед үндэсний эв нэгдэлд хамгаас илүүтэй уршиг тарих үзэгдэл бол нийтээрээ, дээр доргүй, хот хөдөөгүй улс төржин талцах эмгэг юм. Улс төржилт ардчилсан, олон ургалч үзэл дэлгэрсэн, олон намын тогтолцоотой улс оронд байдаг л үзэгдэл бөгөөд улс орны тусгаар тогтнол, аюулгүй байдлыг хангах, тогтвортой хөгжилд хүрэх, хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулах, дарангуйлал, хэсэг бүлгийн ноёрхол, дур зоргын эсрэг нэн чухал хүчин зүйл болох учиртай ажээ.

Гэтэл Монгол Улсад улс төржилт энэхүү утга чанар, хэм хэмжээгээ алдаж, явцуу/олигархи, улс төрийн г.м/ бүлэглэлүүдийн эрх ашгийн төлөө тэмцэл болох магадлал их байгаа нь түүнийг нийгмийн нэн хор уршигтай үзэгдэл болгож байна. Энэ эмгэг нийгмийн амьдралын бүх хүрээ, нийгмийн бүх бүлэг, давхарга тэр бүү хэл нийгмийн үндэс болсон гэр бүлд хүртэл нэвчин халдварлаж, нийгмийн тогтвортой байдал, төрийн удирдлагын нэгдмэл байдал, үндэсний эв нэгдэлд ан цав суулгаад зогсохгүй нийгмийн материал баялгийн хуваарилалт, бүтээн байгуулалт, хөгжлийн бодлогод хүртэл нөлөөлж уршиг тарьж буйг нуух юмгүй.

Ийм нөхцөлд судлаачийн хувьд дараах зүйлсийг санал болгож байна..

Нийгэмд эе эвийн сэтгэлгээг бэхжүүлэх бодлого, үйл ажиллагааны үндсэн чиглэл:

- Төр, иргэний нийгэм, эрдэмтэн судлаачдын хамтын оюун ухаанаар улс үндэстний, ард түмний нийтлэг, язгуур эрх ашиг, эрхэмлэн сахих, хадгалан хамгаалах үнэт зүйлс (нийт улс үндэстний, өрх гэр бүлийн, иргэний г.м.)-ийг шинжлэх ухаанчаар тодорхойлж, баталгаажуулан хэрэгжүүлэх тогтолцоог төлөвшүүлэх;

- Үндэсний аюулгүй байдал, эв нэгдлийн оюун санааны дархлаа нь болсон эх оронч үндэсний үзэл хүмүүжил, үндэсний бахархал, ой санамжийг бэхжүүлэх;

- Нийгмийн баялгийн хуваарилалтад шударга ёсыг тогтоон хэлбэрэлтгүй мөрдөх;

- Нийгмийн дундаж давхаргыг өргөжүүлэх, бэхжүүлэх;

- Төр, нийгмийн удирдлагын бүх институт (субъектүүд)-эд иргэнийг угсаа гарвал, яс үндэс, үзэл бодлоор ялгаварлан гадуурхах, нийгэмд талцал, зөрчилд хүргэж буй улс төржилтийг саармагжуулах, явцуурхан бүлгэрхэх аливаа үзэл, оролдлоготой шийдвэртэй тэмцэх тогтолцоо, механизм (арга хэрэгсэл)-ыг төлөвшүүлэх;

- Угсаатан, ястны эрхийн тэгш байдлыг бодитой хангах.

Энд нэгэн зүйлийг онцлоход эе эвийн тухайд эцэг дээдсийнхээ сургаал номлол, жаяг дэгийг судлах, сурталчлан таниулахын онол, арга зүйн нэн чухал ач холбогдол юм. Нэн ялангуяа улс төрийн хүрээнийхний атгаг зөрчил тэмцэл цадигаа алдаж буй энэ цаг дор төр ёс, хуулиар засаглахуй, шударгыг түших, эе эвийн сэтгэлгээ, номын ёсоор хураахуйн Монгол арга ухаан ундарга болсон учир Чингис хааны андын нөхөрлөлийн тухайд сануулах нь улс төрчдийн баахан өгдөөгөөд байдаг хэрүүл жатгыг дарахад тустай болов уу хэмээн үзнэ.

ЧИНГИС ХААНЫ АНДЫН НӨХӨРЛӨЛ

Монголын төр ёсны 2000 гаруй жилийн түүхэнд Их Монгол Улс байгуулагдсан, Их Засаг хууль гарч үйлчилсэн гээд алтан үсгээр бичигдэн үндэсний ухамсар, ой санамжид мөнхөрсөн үнэт зүйлс, үйл явдал цөөнгүй. Үндэсний ийм эрхэм үнэт зүйлсэд Монголчуудын шударга ёс, эе эвийн сэтгэлгээтэй салшгүй холбоотой Чингис богдын андын нөхөрлөл зүй ёсоор орох бөлгөө.

Хар багаасаа өнчирч, өлөн зөлмөгийн зовлон, урваж шарвахын уршиг хөнөөлийг биеэрээ амсан туулж зүйрлэшгүй их хатан зориг, суу билгийнхээ хүчээр улс Монголоо төвхнүүлж, “Өнөөгийн ертөнцийг үндэслэгч” (Жак Уэторфорд)-ийн алдар хүндийн оргилд хүрсэн хосгүй их үйл хэргийг бүтээсэн суу залиных чөмөг нь Чингис хааны өөрийнх нь андын нөхөрлөл, эе эвийн сэтгэлгээ байжээ.

Тал нутгийн эрэлхэг нүүдэлчдийн (Х.Пэрлээ) эе эвийн хүчний нэгэн ундарга нь болсон энэ нөхөрлөл ган болдоос ч баг бөх, усан болороос ч тунгалаг, эхийн цагаан сүү шиг ариун ажгуу. Учир нь Чингис, түүний ойрын анд нөхдийн нөхөрлөл алдар хүнд, албан тушаалд хүрэх, ашиг завшаан хүртэх зэрэг хир буртаг суулгах, хэврэгшүүлэх муу зүйл, атгаг санаагүй, нэгдмэл зорилгын дор санаа зориг нэгдсэн, харилцан итгэлцэлд суурилсан үнэнхүү шударга, цэвэр ариун үерхэл, нөхөрлөл юм. Чингисийн андын хүрээнд Урианхай, Бэсүд, Ойрад, Татар, Кидан зэрэг угсаатан ястны төлөөлөл багтаж буй бөгөөд чухам үнэнхүү шударга, хичээл зүгэл, ур ухаан, баатар зоригоороо Богд эзнийхээ итгэлийг хүлээсэн андууд байжээ. Тэднээс алдар хүндэд хүрээд санаа буруулсан, итгэл эвдсэн нэгээхэн ч гараагүй байна.

“Хаан хүн жаргахдаа

Төрийнхөө сайнд жаргаюу

Харц хүн жаргахдаа

Төрийнхөө сайнд жаргаюу

Хамаг бүгд жаргахдаа

Эе эвийн сайнд жаргаюу” (“Алтан товч”, 1990).

Чингис богд, түүний дайчин анд нарын үнэнхүү шударга ариун үерхэл нөхөрлөл, түүний үнэ цэнийг богдын нөхдийнхөө ач тусыг магтан өгүүлснээс нь мэдрэгдэж ухаарагдмуй.

Тайлбар: Чингис хааны хамгийн ойр дотнын анд нар (Сайшаал аругай тэднийг Нөхөр бүлгэм гэжээ.)

Чингисийн дөрвөн хушууч {Нууц товчоо-нд} бол Хубилай, Зэлмэ, Зэбэ, Сүбэдэй дөрөв юм.

Чингисийн дөрвөн хөлөг гэдэг бол Боорчу, Мухулай, Борохул, Чилагун (Чулуун) дайчин баатар, шударга сайдыг нь хэлж байна.

Чингисийн хоёр манлай нь Орогуудын Жүрчидэй, Мангуудын Хойлдор хоёр болно.

Чингисийн есөн өрлөг (Чингисийн есөн өрлөгтэй өнчин хөвгүүний сэцэлсэн шастир-т)

1. Сүдсний Сорхон шар,
2. Жалайрайн гуа Мухулай;
3. Зүрчидийн Цуу (Чуу) мэргэн;
4. Аруладын хөлөг Боорчу (Боорчи);

5. Урианханы Зэлмэ;
6. Бэсүүдийн Зэбэ (Зэв);
7. Ойрадын Хар Хиру;
8. Шигихутут (Шихихутуг);
9. Сүбэдэй.

Тэмдэглэл:

- Энд Сүбэдэй баатрын нэр үгүй байгааг Р.Сайшаал абугай тэмдэглэсэн байдаг.
- Ц.Дамдинсүрэн абугай Монголын уран зохиолын түүх-дээ “Цуу мэргэн бол мэргэн сайд Елүй Чуцай мөн” гэжээ.

АЛТ ЭРДЭНЭСТЭЙ Ч ЗҮЙРЛЭШГҮЙ АНД САЙН НӨХДҮҮД МИНЬ (ЧИНГИС ХААН АНД НАРЫНХАА АЧ ТУСЫГ МАГТСАН НЬ)

Цуу (Чуу) мэргэнийг магтсан нь:

Зарлигийг минь алдал үгүй дагаж
 Заасныг минь эндэл үгүй гүйцэтгэж
 Дайсны тэргүүтнийг Тас харваж
 Унасан зээрд морийг нь
 Уулгалан булааж
 Хатгалдах дайсныг
 Хага цохиж
 Зөрчилдөх дайсныг
 Цөм цохисон
 Зүрчидийн Цуу мэргэн минь гэжээ.

Сайн шувуу модоо олж суудаг Сайн түшмэд эзнээ олж үйлчилдэг ажгуу.

Чуу мэргэн (Елюй Чусай) тэнгэрээс маньд соёрхов, хожим төр улс, ард иргэд, цэрэг засгийн явдалд томилог хэрэглэвээс зохимой. [МНТ-149]

Сорхон шард өгүүлсэн нь:
 Үсэн хийгээд унгасны тэргэнд
 нуусан ахай минь
 Улс Монголын эзэн болгоод хаан
 оронд хүргэсэн их ачит минь
 Усгал зохисоо, өсөд үл суутгагч
 гүр зүрхт минь
 Өсөд гэм үл тавигч зөөлөн ёнхор
 мэт (сэтгэлт) Сорхон шар минь.
 [МНТ-219]

Аруладын Боорчид хэлсэн нь:
 Найман шарга морийг нэхэхэд
 Наран гарах цагт учирч
 Насан турш хүчээ өгсөн
 Наху баяны хөвгүүн
 Сайн хөлөг Боорчин минь
 Айл зуур явахад

Алаг бяруу мэт аашт
 Алалдах дайсантай учрахад
 Амь биеэ үл хайрлагч
 Хөлөг Боорчи минь
 Ханилан явах цагт
 Хашин хар бяруу мэт
 Харьтан дайсантай учрахад
 Харцага шувуу мэт довтлон орогч
 Хөлөг Боорчи минь
 Инээлдэн явах цагт
 Ижил хар бяруу мэт аашт
 Идэмхий дайсан учрахад
 Эрэмгий шувуу мэт довтлон орогч
 Хөлөг Боорчи минь
 Наадан инээлдэн явах цагт
 Нялх унага мэт аашт
 Наад цаад лугаа хатгалдахад

Начин шонхор мэт довтлон орогч
Хөлөг Боорчи минь
Хатуу дайсан учрахад
Харил буцалгүй явж
Хаан эзнийхээ биеэс
Харин хол үл эчигч
Арга сайт хөлөг Боорчи минь.
[МНТ-149]

Урианханы Зэлмэд:
Ороо гөрөөсний
Отлого болсон
Омогт дайсны

Зэв жанжин, Сүбэдэй баатар нарт:

...Одоо Хубилай, Зэлмэ, Зэв, Сүбэдэй та дөрвөл сайн нохой мэт итгэлтэй нөхөд мөн. Та нарыг хаана ч илгээвэл,

Хүр гэсэн газар хүрч
Хүр чулууг хэмх цохин
Халд гэсэн газар халдаж
Хад чулууг хага цохин
Цэгээн чулууг бутаргал
Цээлийн усыг цалгитал
Ниргэж, нядалж явав

Хубилай, Зэлмэ, Зэв, Сүбэдэй Дөрвөн нохойгоо зорьсон газартаа явуулаад Боорчи, Мухулай, Борохуль, Чулуун дөрвөн хүлэг баатраа дэргэдээ авч, хатгалдах өдөр хамгийн түрүүнд уруд мангудын цэргийг Жорчидай, Хуйлдар хоёроор толгойлуулан мордуулбал сая миний сэтгэл бүрнээ амардаг билээ. [МНТ-209]

Татарын Шихихутугт хэлсэн нь:

Байлдах цагт бүрээг минь сүрдэл үгүй дуурсгагч луу минь
Бэхлэн хэлэлцсэн үгийг минь гадагш үл өгүүлэгч битүү лонх минь
Балдагт шор тэргүүтэй мэсийг минь хурцаггагч чулуун билүү минь
Бууц нутгийг минь засагч Шихихутуг минь... гэсэнд [МНТ-149]

Шихихутуг хариуд нь:

Үлэмж их жаргалдаа үтэр бүү ташуур
Үнэн төр. жанжныхаа тул амь бие тэвч
Үргэлж хүч өгсөн нөхрөө бүү март

Өчүүхэн бодол үгүй юманд орохоо тэвчилтэй буй заа хэмээн андгайлжээ. [МНТ-149]

Жалайрын Мухулайд хэлсэн нь:

Дайсныг даралцаж
Олзыг оруулалцаж
Ирэх дайсны ирийг мохоож
Буцах дайсны

Зүрхийг чичрүүлсэн
Унах морьгүй болоход
Унаа авчирч өгсөн
Ундаасан цангах цагт
Уух дарс өгсөн
Сэргэг бага нойртой
Сэцэн мэргэн ухаантай
Улс, төрийн төлөө
Урьд цагаас зүтгэсэн
Урианханы сайн Зэлмэ минь.
[МНТ-149]

Борвийг хянгардаж

Хураан авч ирсэн

Жалайрын сайн Мухулай минь. [МНТ-149]

Чингис хаан:

Түймэр мэт дайнд түгдрэлгүй орогч сүрт заан минь

Туг, сүлдийг минь барьж үл хөдөлгөгч чулуун хөшөө минь

Төлөв их хуримд минь хошуучлан байж хүргэгч дэлгэр баян минь

Тэнцэхүй мөрт (дайнд) мөсөн (мэсэн) бодлыг минь барьж айлгагч

Гоо Мухулай минь чи нэг үг өгүүл гэсэнд

Мухулай хариу өгүүлдүүн:

Гүн их далай мэт сэтгэлийг үл долгидон (долгилуулан)

Хүнд их төр, шашнаа дээд тэнгэрээс гуйгаад

Хүний өшөөтөн дайсныг хатуу засгаар түйтгээд (дараад)

Хөвчин их улсаа цул авираар дурыг авах хэрэг буй гэжээ. [МНТ-149]

Чүшини Борохулд хэлсэн нь:

...Та нар бол миний өгөх соёрхлоос дээгүүр зэрэгтэй. Миний эх (Өүэлэн эх)

Шихихутуг, Борохул, Хүчү, Хөхөчү та дөрвийг дүрвэсэн иргэний нүүсэн нутгаас

Хөдөөнөөс олж

Эгэмнээс чинь татаж

Хөлдөө бүүвэйлж

Эрийн зэрэгт оруулж

Хүмүүжүүлэн тэтгэж

Хөвүүд бид нөхөр болгоё гэж

Хүзүүнээс чинь татаж

тэжээжээ.

Хүний зэрэг болгож

Миний эхийн тэжээсэн ачийг та нар их хариулан зүтгэв. Борохул надад нөхөр болж Хурдан аянд мордож, хуртай ус тохиолдовч хоосон хонуулсан удаагүй. Яаралтай дайнд мордож, ямар ч бэрхшээл тохиолдовч, шөл тасалдуулж, өл алдуулж байсангүй...”гэх зэргээр андынхаа ач тусыг бахархан өгүүлсэн нь түүхнээ үлджээ.

4. Дүгнэлт

Эе эвийг хичээх, үерхэл нөхөрлөлдөө үнэнч байх нь монголын эгэл түмний үеэс үед дамжин дархлагдсан зан чанар юм. Харин хагарал тэмцлийн хамаг уршиг эрх баригчдын эрх мэдэлд шунасан, өс хонзон өвөрлөсөн атгаг санаа, бодлогоос үүдэлтэйг өнгөрсөн түүх маань бидэнд сануулсаар буй.

Төрийн хүн, хувийн хүсэл эрмэлзлээ улс үндэстнийхээ нийтлэг ашиг сонирхол, шударга ёсонд захируулах, харилцан хүндэтгэл, ойлголцол, итгэлцлийн ухаарал мэдрэмж нь монголын төр, улсын энх амгалан оршихуй, төр, түмний ажил үйлс өөдрөг бүтэмжтэй байхын үндэс болдсоор ирсэн нь Чингис богдын андын бат нөхөрлөл, буурал түүхийн маань алтан сургамж. Монголчуудын энэ эрхэм нандин чанар эдүгээ ч Монголын төр улсын бодлого үйл ажиллагааны үнэт зүйл нь байх учиртай бөгөөд бидний цөөхөн монголчууд дотооддоо өөр хоорондоо төдийгүй хилийн чанад дахь хөрш, анд түнш нартайгаа тогтоосон найрамдал нөхөрлөлдөө, олон улсын хамтын нөхөрлөлийн өмнө хүлээсэн үүрэгтээ туйлбартай, чин үнэнчээр биелүүлж байдгаар нотлогдоно.

5. Эх сурвалж

- “Монголын нууц товчоо”, Ц.Дамдинсүрэнгийн орчуулга, УБ., 2009.
- Ч.Жүгдэр, Монголд феодализм тогтох үеийн нийгэм, улс төр, гүн ухааны сэтгэлгээ, УБ., 1984.
- Лувсанданзан, “Алтан товч”, УБ., 1990.
- М.Правдин, “Чингис хаан түүний өв...”, УБ., 2005.
- Рашид Ад Дин, “Судрын чуулган”, Нэгдүгээр боть.
- Р.Сайшаал, “Чингис хааны товчоон...”, УБ., 2010.
- Я.Ганбаатар, Ц.Ганбаатар, “Чаньчун бомбын өрнө этгээдэд зорчсон тэмдэглэл”, УБ., 2010.
- П.Карпини, “Монголчуудын түүх”, УБ., 1988.
- Р.Лейтхэм, “Марко Поло”, УБ., 2012.
- М.Жувейни, “Дэлхийг байлдан дагуулагчийн түүх”, Нэгдүгээр боть, УБ.
- В.Инжаннаши, “Хөх судар”, УБ., 2006.
- Ц.Нацагдорж, “Чингис хааны сургаалын товчоон”, УБ., 2008.
- Ш.Чоймаа, “Оюун түлхүүр”, УБ., 2007.
- Ж.Уэтерфорд, “Өнөөгийн ертөнцийг үндэслэгч Эзэн Чингис хаан”, УБ., 2009.
- С.Нарангэрэл, “Монголчуудын зан суртахууны гарвал”, УБ., 2010.
- С.Нарангэрэл, “Чингис хааны ёс суртахуун ба эрх зүйн шастир”, УБ., 2014.
- Л.Н.Гумилев нар, “Хар домог”, УБ., 1992.